



66

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 02 сарын 01

№ 31

Улаанбаатар
хот

Пүүс байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Үйлдвэрлэл-үйлчилгээний "Хөлөг" пүүсийг баазынхаа харьяанд аж ахуйн бүрэн тооцоон дээр байгуулан ажиллуулахыг /н.Алтаншанд/-д зөвшөөрсүгэй.

2. "Хөлөг" пүүсэд шаардагдах тоног төхөөрөмж, бараа хангамж, солилцоог хариуцан гүйцэтгэх, гадаад худалдааны эрх олгуулах асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, ажлаа эрхлэн явуулахад шаардагдах орон тоо, цалингийн санг баталж өгөхийг 38 дугаар бааз /н.Дашзэвэг/-д даалгасугай.

3. Пүүсийн тоног төхөөрөмж, материал худалдан авах болон зайлшгүй шаардлагатай бусад зардлыг БНМАУ-ын засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолыг үндэслэн ажил эрхлээгүй хүмүүсийг хөдөлмөрт оруулах, ажлын нэмэгдэл байр бий болгоход дэмжлэг үзүүлэх сангаас гаргахыг Сүхбаатарын району Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа /н.Будрагчаа/-нд хариуцуулсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА 2  Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА 2  Ч.СУМААХҮҮ